

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН
2018 ОНЫ 08 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2018 оны 08 дугаар сарын 25

Чойбалсан хот

Арга хэмжээ /гарц/-ийн шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/-ийн хүрэх түвшини	Жинхэнэ гүйцэтгэл /тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин/	Үнэлгээ /нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо/
1	2	3
<p>1.1.1. Орон нутгийн төрийн захиргааны болон хяналтын байгууллагуудаас зохион байгуулсан уулзалт, зөвлөгөөн, сургалтанд оролцох Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Байгууллагын үндсэн чиг үүргийг талаар үнэн зөв ойлголттой болсон байна Хугацаа: Сардаа</p>	<p>Бүсийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Эрдэнэтуяа Дорнод аймгийн “Удирдах ажилтны шуурхай хуралдаан”-д 3 удаа суусан. Сүхбаатар аймагт мэргэжилтэн Н.Эрдэнэдулам мөнс тус аймгийн удирдах ажилтны шуурхай хуралд байгууллага төлөөлөн сууж байсан.</p>	
<p>1.1.2. Нутгийн захиргааны болон хяналтын бусад байгууллагатай хамтран ажиллах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль тогтоомжийн талаар нэг мөр ойлголт өгөх Хугацаа: Сардаа</p>	<p>Дорнод аймгийн “Баяндун” сумын Засаг дарга Х.Хүрэлчулуунаас ирүүлсэн №1/381 албан хүсэлтийн дагуу тус сумын нутагт уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа “Про Аурум” ХХК, “ММЛ” ХХК-нуудад хамтран хяналт шалгалтыг хийж хариуг 2018.08.21-ны өдрийн 17/ 203 тоот албан бичгээр, Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Мөнхгэрэлийн 2018.08.10-ны өдөр ирүүлсэн №1/496 албан хүсэлтийн дагуу Матад суманд үйл ажиллагаа явуулдаг “СПЕК” ХХК-нд хяналт шалгалтыг хийж, хариуг 2018.08.21-ны өдрийн 17/ 202 тоот албан бичгээр өгч хамтран ажиллалаа. Чойбалсан хотын 80 жилийн ойтой холбогдуулан гаргасан Хэрлэн сумын Засаг даргын 07 дугаар сарын 31-ний өдрийн А/247 дугаар “Үүрэг чиглэл өгөх тухай, А/248 дугаар “Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд 08 дугаар сарын 20-ний өдөр цэвэрлэгээ зохион байгууллаа. Цэвэрлэгээнд байгууллагаас Бүсийн төвд ажиллаж байгаа 12 албан хаагч оролцож хувиарт газар болох одоогийн байрлаж байгаа “Дорнод</p>	

	их сургууль"-н хашааны зүүн талаас хуучин журмын хашааны баруун булан хүртэлх замын 2 тал болоод ойр орчны 50м газрын зам талбайн хог хаягдал, зэрлэг шарилжыг зулгаан цэвэрлэсэн.	
1.2.1. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь газрын ажиллах журам”-ын хэрэгжилтийг ханган, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажиллах, үр дүнг тайлагнах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Үйл ажиллагааны үр дүн гарсан байна Хугацаа: Сардаа	Байгууллагын даргын баталсан удирдлага зохион байгуулалтын А/263 тоот “Хилийн боомтод сансарын холбооны суурин утас ашиглуулах тухай”, А/269 тоот “Сүлжээний доголдол гарсан үед ажиллах тухай”, А/275 тоот “Наймдугаар сарын ур чадварын нэмэгдэл олгох тухай”, хүний нөөц боловсон хүчинтэй холбоотой Б/215 тоот “Т.Баярсайханы хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай”, Б/219 тоот “Б.Ренчиндоржийг ажилд томилох тухай”, Б/225 тоот “Л.Бархасбадийг мэргэжилтнээр томилох тухай” тушаал, шийдвэрийг тус тус хүлээн авч хэрэгжүүлсэн.	
2.1.1. Монгол Улсад цагаачлан оршин сууж байгаа гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт болон иргэний харьяаллын асуудлаар гаргасан бусад хүсэлтийг хүлээн авч зөвлөгөө өгөх, хүлээн авсан баримт бичгийн бүрдлийг Харьяатын газарт хүргүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа	Монгол Улсад цагаач хэлбэрээр оршин суудаг БНХАУ-ын 1 иргэний оршин суух зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргасан материалыг хүлээн авч илтгэх хуудсын хамтаар Виз, зөвшөөрлийн газарт явуулсан.	
3.1.1. Гадаадын иргэнд Монгол Улсын энгийн зэргийн виз олгох, хугацаа сунгах, визийн зөвшөөрөл хүссэн тухай Виз, зөвшөөрлийн газарт уламжлан шийдвэрлүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа	Бүсийн газар түүний харьяа хилийн боомтуудад БНХАУ-ын 177 иргэнд зохих ангилал, зориулалтын дагуух визийг олгосон. Үүнд: -“ НГ ” ангиллын визийг 55 иргэнд олгосон байна. Үүнээс: - Нэг удаагийн “орох” зориулалттай виз – 5 /ЭСЯ, ДТГ-аас алдаатай олгогдсон визийг хүчингүй болгож, шинээр олгосон/ - Нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз -7 - Хоёр удаагийн “гарах-орох” зориулалттай виз -4 - Олон удаагийн “гарах-орох” зориулалттай виз -14 - Визийн шилжүүлэг- 25; - “ В ” ангиллын визийг Виз, зөвшөөрлийн газраас олгосон визийн зөвшөөрлийн дагуу 4 иргэнд олгосон. Үүнээс	

	<ul style="list-style-type: none"> - Нэг удаагийн “орох” зориулалттай виз -3 - Олон удаагийн “орох” зориулалттай виз- 1 - Визийн шилжүүлэг- 1 иргэнд; - “Т” ангиллын олон удаагийн “гарах-орох” зориулалттай виз -1; - “Н” ангиллын нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз -2; - “J” ангилалын визийг Виз, зөвшөөрлийн газраас олгосон визийн зөвшөөрлийн дагуу 114 иргэнд олгосон. Үүнээс - Нэг удаагийн “орох” зориулалттай виз 23 иргэнд - Хоёр удаагийн “орох” зориулалттай виз 91 иргэнд тус тус олгож ажиллалаа. 	
<p>3.1.2. Монгол Улсад зорчих хувийн урилга олгох Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	Тус сард урилга хүссэн иргэн байхгүй	
<p>3.1.3. Оршин суух зөвшөөрөл, хугацаа сунгах, хасах, оршин суух үнэмлэх авах, өөрчлөлт бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авах, хянах хүсэлтийг хүлээн авч Виз, зөвшөөрлийн газарт уламжлан шийдвэрлүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	Монгол Улсад цагаач хэлбэрээр оршин суудаг БНХАУ-ын 1 иргэн, GB-1 хэлбэрээр оршин суудаг БНХАУ-ын 1 иргэн, нийт 2 иргэний оршин суух зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргасан материалыг хүлээн авч илтгэх хуудсын хамтаар Виз, зөвшөөрлийн газарт явуулсан.	
<p>3.1.4. Монгол Улсад түр ирэгч гадаадын иргэнийг бүртгэх, хасах, түүнчлэн хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй гадаадын иргэнийг бүртгэх, хасах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу НГ ангиллын орох визээр орж ирсэн БНХАУ-ын 40 иргэн, визийн сунгалт хийлгэсэн 8 иргэнийг түр ирэгчээр бүртгэсэн. Мөн зөрчил гаргасан 10 иргэнийг түр ирэгчээр бүртгэж, 12 иргэнд хасалт хийсэн байна. Бүсийн хэмжээнд нийт түр ирэгчээр 58 иргэнийг бүртгэж, 12 иргэнд хасалт хийсэн байна.</p> <p>2 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу нийт 2 иргэний НГ ангиллын оршин суух зөвшөөрөлд хасалт хийсэн. /ОСЗ хасалт нийт-2/</p>	
<p>3.1.5. Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суухаар анх удаа ирсэн гадаадын иргэний хурууны хээ бусад мэдээллийг журмын дагуу авч нэгдсэн санд оруулах</p>	Баянхошуу боомт БНХАУ-ын 2 иргэн, Бичигт боомт БНХАУ-ын 35 иргэн, Бүсийн төвд БНХАУ-ын 61 иргэн, нийт 98 иргэний зураг хурууны хээг авч “Transient card system” програмаар бүртгэн, мэдээллийн баазад оруулсан.	

<p>Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>		
<p>3.2.1. Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суугаа гадаадын иргэн, аж ахуй нэгж, байгууллагад удирдамжийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дангаар буюу хяналтын бусад байгууллагатай хамтран зохион байгуулна Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>ГИХГ-ын Зүүн бүс дэх газар нь тайлангийн хугацаанд Байгууллагын даргын УБ-02/2018-007, бүсийн газрын дарга болон хяналтын улсын ахлах байцаагчийн №17/02-201828-17/02-201831 тоот удирдамжийн дагуу төлөвлөгөөт 2, төлөвлөгөөт бус 3, нийт 5 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.</p>	
<p>3.2.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан зөрчил гаргасан гадаадын иргэдийн зөрчлийг арилгаж, зөвлөгөө өгч ажиллана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Нийт хяналт шалгалтанд 10 аж ахуй нэгжийн, гадаадын 295 иргэн хамрагдсанаас 15 зөрчлийг илрүүлж, БНХАУ-ын 15 иргэнд 3,640.000.00 /гурван сая зургаан зуун дөчин мянга/-н төгрөгийн торгуулийн арга хэмжээг тус тус ногдуулсан. Үүнээс: Байгууллагаар 3 иргэнд 790,000.00 /долоон зуун ерэн мянга/-н төгрөг, хувь хүнд 2,850,000.00 /хоёр сая найман зуун тавин мянга/-н төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.</p>	
<p>3.2.3. Хууль, тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Тайлангийн хугацаанд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн БНХАУ-ын 6 иргэнийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1.7 дахь хэсэг, 2010 оны Засгийн газрын 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 3.7 дахь заалтад заасны дагуу 3 жилийн хугацаанд Монгол Улсад дахин орох эрхгүйгээр Монгол Улсаас албадан гаргасан.</p>	

<p>3.2.4. “Монгол Улсын виз олгох журам”-ын 5.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр визийг хүчингүй болгоно Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>ЭСЯ, ДТГазраас алдаатай олгосон буюу визэнд засвар хийж баталгаажуулсан 5 виз, Зүүн бүс дэх газраас алдаатай олгосон 1 визийг хүчингүй болгож, нийт 6 виз шинээр олгосон. Дээрхээс бусад шалтгаанаар буюу Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын виз олгох журам” –ын 5.2.7 дахь заалтыг үндэслэн БНХАУ-ын 1 иргэний олон удаагийн “орох” зориулалтын визийг хүчингүй болгосон /Баянхошуу боомт</p>	
<p>3.2.5. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, тогтоомжид заагдсан үндэслэлээр гадаадын иргэнийг Хил дээрээс буцаах арга хэмжээг журмын дагуу хэрэгжүүлж ажиллана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>“Баянхошуу” боомтод ГИЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.6 дах заалтыг үндэслэн /Монгол Улсад байх буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй/ БНХАУ-ын 1 иргэн; “Хавирга” боомтод мэргэжилтэн А.Нэмэхбаяр; ГИЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.6 дах заалтыг үндэслэн /Монгол Улсад байх буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй/ БНХАУ-ын 1 иргэн; “Бичигт” боомтод хяналтын улсын байцаагч Ц.Өлзиймөнх ГИЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.6 дах заалтыг үндэслэн /Монгол Улсад байх буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй/ БНХАУ-ын 2 иргэн; Бүсийн хэмжээнд БНХАУ-ын нийт 4 иргэнийг улсын хилээр нэвтрүүлэлгүйгээр буцааж ажилласан.</p>	
<p>4.1.1 2018 оны Бүсийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт болон хүний нөөц, бусад шаардлагатай судалгаа мэдээллийг гарган Тамгын газар, БОНХ-т хүргүүлэх, Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Дээд шатны байгууллага, албан тушаалтан хүссэн мэдээллээ авсан байна. Хугацаа: Сардаа</p>	<p>Төвөөс ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу Тамгын газарт хагас жилээс хойш сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах талаар хийсэн ажлын тайлан, төрийн одон медальтай албан хаагч нарын судалгаа, 2018 онд сургалтанд хамрагдсан албан хаагчдын судалгаа, төрийн үйлчилгээний албан хаагч нарын 8 дугаар сарын ур чадварын нэмэгдэл олгуулах санал, өргөдөл гомдлын мэдээний хамт, Боомт орон нутгийн хэлтэст хилийн бүсийн газрын 7 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт, мөн сарын инфо мэдээ, Бүсийн даргын Үр дүнгийн гэрээний долоодугаар сарын биелэлт, 8 дугаар сарын төлөвлөгөө, Байгууллагын даргын гаргасан албан даалгаваруудын биелэлтийг тус тус гаргаж “и оффис” хаягаар хүргүүлсэн. Мөн Байгууллагын даргын 2018 оны 06 сарын 14-ний өдөр баталсан Гадаадын иргэн, харьяатын газрын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаатай танилцсан тухай баталгааг тус газрын нийт 29-н албан хаагчаас, шинээр томилогдсон 2 албан хаагчаас “Төрийн болон байгууллагын нууцыг задруулахгүй байх баталгаа”-г тус тус авч ажилласан байна.</p>	

<p>5.1.1. Зарим албан хаагч нарыг Сэлэнгэ аймгийн байгалын үзэсгэлэнт газраар аялуулах, хойд бүсийн газрын ажил байдалтай танилцан туршлага солилцох Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Мэргэшлийн ур чадвар нэмэгдсэн байх Хугацаа: Сардаа</p>	<p>Ажил зохион байгуулагдаагүй.</p>	
<p>5.2.1. Байгууллагын баримт бичгийн эргэлтийг зохион байгуулах, бүртгэлжүүлэх, сан үүсгэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p><u>Ирсэн бичиг:</u> Гадаадын иргэн харьяатын газраас 2, бусад байгууллагаас 7 нийт 9 албан бичиг ирж, үүнээс хариутай 7 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд өгч шийдвэрлэсэн. <u>Явсан бичиг:</u> Гадаадын иргэн, харьяатын газарт 3, бусад байгууллагад 11 нийт 14 албан бичиг явуулж үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, албан бичгийн хариуг хүргэж ажилласан. <u>Өргөдөл:</u> Албан хаагчдаас – Хувийн чөлөө хүссэн 2, хилийн боомтоос очиж эмнэлэгт үзүүлэх хүсэлт гаргасан 1, нийт 3 өргөдөл хүлээн авч журмын дагуу шийдвэрлэсэн. <u>Иргэнээс</u> – Тус сард иргэнээс гаргасан өргөдөл гомдол байхгүй.</p>	
<p>6.1.1. Төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Зориулалтын дагуу зарцуулсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>2018 оны 8 дугаар сард 37,812,500.00 төгрөгийн санхүүжилтийг авсан. Үүнээс 38,232,987.95 төгрөгийн зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу хийж гүйцэтгэсэн.</p> <p>2018 оны 07 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 291,071,800.00 төгрөгийн санхүүжилт, 255,358,973.42 төгрөгийн гүйцэтгэлтэй, 35,812,826.58 төгрөгийн үлдэгдэлтэй гарсаныг газрын даргаар баталгаажуулан аймгийн төрийн сан болон ГИХГ-ын санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.</p> <p>06 дугаар сарын цалин хөлсний нийгмийн даатгалын тайлан нь нийт 29 албан хаагчдын 31,963,042.73 цалин, ногдол 7,290,394.39 төгрөг гарсныг нийгмийн даатгалын санд шилжүүлж, цахимаар шивж цаасаар баталгаажуулсан.</p>	

<p>6.1.2. Тэмдэгтийн хураамжийн болон хүү, торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Хяналтын улсын байцаагч болон боомтын визийн хуудасны 07 дугаар сарын тайлангаар улсын тэмдэгтийн хураамж орлогод 8,864,000.00 төгрөг, хүү, торгуулийн орлогод 730,000.00 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.</p>	
<p>6.2.1. Бүсийн төв болон бусад нэгж, техник хэрэгсэлд шаардлагатай бараа материал, эд зүйлээр нь хангаж ажиллах Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тооцоо судалгаа хийгдсэн байна Хугацаа: Сардаа. <i>/тусгай арга хэмжээ/</i></p>	<p>Хангалт үйлчилгээний газраас ирүүлсэн албан хаагч нарын нормын хувцас Футболк 7 ширхэг, хар цамц 54 ширхэгийг тоо ёсоор нь хүлээн авч албан хаагч нарт захиалгын дагуу хүлээлгэн өгч өгсөн картжуулан ажилласан. Мөн эрүүл мэндийн шалтгааны улмаас чөлөөлөгдсөн жолооч Т.Баярсайханаас 8 дугаар сарын 07-ны өдөр 75-55 ДОА, 65-99 ДОА улсын дугаартай автомашинуудыг техникийн комиссын хамт хүлээж авч шинээр томилогдсон жолооч Б.Ренчиндожид хүлээлгэн өгсөн. Баянхошуу боомтод визийн хуудас 300 ширхэг, визийн анкет маягт1 300 ширхэгийг олгосон. Хяналтын улсын байцаагч З.Өлзийбаяр нь шилжих болсонтой холбогдуулан шийтгэвэрийн хуудас маягт1-г 10 ширхэг, шийтгэлийн хуудас маягт 250 ширхэгийг буцааж хүлээн авсан.</p>	
<p>6.2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь хэсэг заасны дагуу Зүүн бүс дэх газрын эд хөрөнгийн хагас жилийн тооллогыг хийж холбогдох албан тушаалтанд танилцуулах Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тооцоо судалгаа хийгдсэн байна Хугацаа: Сардаа.</p>	<p>Бүсийн газрын даргын А/21 тоот тушаалын дагуу бүсийн хагас жилийн тооллогыг зохион байгуулж Сүхбаатар аймаг дахь хэлтэс, Хэнтий аймаг дахь төлөөлөл, ОХУ-д гарцтай 2 боомт, БНХАУ-д гарцтай 4 боомтын үндсэн хөрөнгө, материалын 2018 оны хагас жилийн тооллогыг хийж гүйцэтгэлээ. Нийт 271 ширхэг 506,539,991.89 төгрөгийн үндсэн хөрөнгө, 845 ширхэг 56,437,323.90 төгрөгийн хангамжийн материал тоологдсон байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 06-ний өдрийн А-5/1026 тоотын дагуу үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн тоног төхөөрөмж 10 ширхэг 20,570,902.00, тавилга, эд хогшил 20 ширхэг 2,389,134.00 буюу нийт 30 ширхэг 22,960,036.00 төгрөгийн хөрөнгө актлагдсан.</p>	
	<p>07 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 24-ны өдрийг дуустал Бүсийн газар болон харьяа хилийн боомтуудын сүлжээнд хяналт тавьж, ISM систем гарсан зөрчилгүй хэвийн ажилласан.</p>	

<p>7.1.1. “ISM” системийн сайжруулалт, хөгжүүлэлтийг тухай бүр гүйцэтгэж, албанд ашиглана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: <i>Найдвартай системтэй байна</i> Хугацаа: Жилдээ <i>/тусгай арга хэмжээ/</i></p>	<p>Хяналтын улсын байцаагч Д.Мөнхбаяр, мэргэжилтэн Б.Одмаа нарын “ISM” програмын шилжүүлэх эрхийг бүртгэн авч, мэдээллийн технологийн хэлтэст танилцуулан тус програмын эрхийг шилжүүлсэн. Eset endpoint security антирусны програмыг хилийн боомтуудын нийт 10 компьютеруудад 08 дугаар сарын шинэчлэлтийг хийж хортой кодоос урьдчилан сэргийлсэн.</p>	
<p>7.1.2. Албан үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютер, тоног төхөөрөмжийн урсгал засвар үйлчилгээ, эвдрэл гэмтлийг тухай бүр засварлах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: <i>Үйл ажиллагааны тасралтгүй байдал хангагдсан байна</i> Хугацаа: Сардаа</p>	<p>Ульхан, Эрэнцав, Баянхошуу, Сүмбэр, Бичигт боомтуудад сансрын холбооны суурин утсыг суурьлуулж ашиглалтад оруулан албан хэрэгцээнд ашиглаж байна. Баянхошуу боомтын хурууний хээний зөөврийн компьютерийг бүсийн газарт авчруулан форматлан, системийн алдааг засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан. Бичигт боомтын хурууны хээний зөөврийн компьютерийн системийн алдааг мэргэжилтэн Х.Тайванбаатартай хамтран засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан. Эрэнцав боомтын сансрын холбооны суурин утас гаднаас дуудлага авахгүй гэмтэлтэй байсныг мэргэжилтэн Г.Намуунзаяатай хамтран засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан. Ульхан боомтын сансрын холбооны суурин утас сүлжээнд холбогдохгүй байсныг “Монвсат нэтворк” ХХК-тай хамтран засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан. Видео бичлэгийг 6 ширхэг DVD дискэнд хуулбарлан Хяналтын улсын ахлах байцаагч Б.Эрдэнэтуяад хүлээлгэн өгсөн.</p>	

ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР